



ДИЖИТАЛ ТӨЛБӨРИЙН СИСТЕМ БА ЭДИЙН ЗАСГИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ: ЭРХ ЗҮЙ-ЭДИЙН ЗАСГИЙН ШИНЖИЛГЭЭ

DIGITAL PAYMENT SYSTEMS AND ECONOMIC SECURITY: A LAW AND ECONOMICS ANALYSIS

Эрдэнэбат Хангал¹

University of Internal affairs, Mongolia, E-mail: hangal_uk@yahoo.com

ӨГҮҮЛЛИЙН ТУХАЙ

Түлхүүр үгс:

дижитал төлбөрийн систем, эдийн засгийн аюулгүй байдал, финтек, өгөгдлийн засаглал, хүний эрх

Нийтлэлийн түүх:

Хүлээн авсан: 2026, 03 сар
Шинэчилсэн: 2026, 03 сар
Хүлээн зөвшөөрсөн: 2026, 04 сар

Keywords:

Digital payment systems, Economic security, Law and Economics, FinTech, Data governance, Human rights

Article history:

Received March, 2026
Revised March, 2026
Accepted Apl, 2026

ХУРААНГУЙ

Дижитал төлбөрийн систем нь санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, гүйлгээний зардлыг бууруулах, эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх чухал хэрэгсэл болж байгаа хэдий ч кибер эрсдэл, өгөгдлийн төвлөрөл, санхүүгийн бүрэн эрх, хүний эрхийн хамгаалалтын шинэ сорилтуудыг бий болгож байна. Энэхүү өгүүлэлд дижитал төлбөрийн системийн мөн чанар, эдийн засгийн аюулгүй байдалд үзүүлэх нөлөө, эрх зүйн зохицуулалтын шаардлагыг шинжилнэ. Судалгааны үр дүнд дижитал төлбөрийн систем нь зөвхөн санхүүгийн технологи бус, харин эдийн засгийн тогтвортой байдал, өгөгдлийн засаглал, үндэсний аюулгүй байдлыг хангах эрх зүйн институт болохыг тогтоов.

Digital payment systems have become an important instrument for expanding access to financial services, reducing transaction costs, and enhancing economic efficiency. At the same time, however, they generate new challenges related to cybersecurity risks, data concentration, financial sovereignty, and the protection of human rights. This article examines digital payment systems through the methodological framework of Law and Economics, analyzing their institutional nature, their impact on economic security, and the necessity of appropriate legal regulation. The study finds that digital payment systems should be understood not merely as financial technologies but also as legal institutions that play a significant role in ensuring economic stability, data governance, and national security.

Энэ өгүүлэл CC BY-NC лицензийн дагуу нээлттэй хандалтын эрхтэй.

¹Шихихутуг их сургуулийн Бизнесийн удирдлагын тэнхимийн ахлах багш, докторант



1. Танилцуулга

Дижитал төлбөрийн систем нь Монгол Улсын эдийн засгийн аюулгүй байдалд ямар эрсдэл, боломж үүсгэж байгаа бөгөөд эрх зүйн зохицуулалт уг эрсдэлийг хэрхэн бууруулах боломжтой вэ?" гэсэн судалгааны асуулт тавьж, энэ хүрээнд судалгааг хийлээ.

Дэлхийн Банкнаас гаргадаг статистик үзүүлэлтээр, нийт хүн амд эзлэх интернэт хэрэглэгчдийн хувь 2015 онд 40 хувь байсан бол 2024 он гэхэд 68 хувь хүрч, интернэтийн хүртээмж эрчимтэй өссөн үзүүлэлттэй байна. Үүний үр дүнд дижитал орчин дахь эдийн засгийн идэвх нэмэгдэж, цахим хэлбэрийн үйлчилгээ, үйл ажиллагаа өргөжин тэлжээ. Герман гаралтай эдийн засагч, зохиолч, олон улсын бизнес ба бодлогын эксперт Франк Юрген Рихтер санхүүгийн зах зээл нь дэлхийн эдийн засгийн үйл ажиллагааг хөдөлгөгч гол хүчин зүйл хэдий ч түүний хүртээмж хангалтгүй хэвээр байгааг онцолж, уг асуудлыг технологийн дэвшлээр шийдвэрлэх боломжийг дижитал төлбөрийн хөгжлөөр тайлбарласан байна. Тэрээр дижитал төлбөр болон финтек технологийн хөгжил нь зөвхөн эдийн засгийн өсөлтийг дэмжихээс гадна санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх, улмаар урт хугацаанд нийгэм, эдийн засгийн бүтцийг өөрчлөх стратегийн ач холбогдолтой менахизм гэж үзэж болно. Үүнийг бодит болгохын тулд Засгийн газрууд инновацыг дэмжсэн бодлого, зохицуулалтын орчин бүрдүүлэх нь зайлшгүй шаардлагатай болохыг онцолсон байна².

Орчин үеийн эдийн засгийн суурь бүтцийн нэг нь төлбөрийн систем мөн бөгөөд мөнгөний эргэлт, гүйлгээ, зах зээлийн хэвийн үйл ажиллагааг хангадаг. Уламжлалт төлбөрийн систем нь бэлэн мөнгө болон төвлөрсөн банкны институтэд тулгуурлан ажиллаж ирсэн.

Харин дэлхий даяарх харилцаа холбоо, мэдээллийн технологийн хурдацтай хөгжил, инновац, даяаршил, хэрэглэгчийн зан төлвийн өөрчлөлт зэрэг нь мөнгөн солилцоо, санхүүгийн зуучлал зэрэг санхүүгийн зах зээлийн уламжлалт зохицуулалтын механизмыг үндсээр нь өөрчилж, дижитал системийг хөгжүүлснээр төлбөрийн систем нь санхүү, технологи, эрх зүйн салбаруудын огтлолцол бүхий цогц систем болон хөгжих болсон. Дижитал төлбөрийн системийн хурдацтай хөгжил нь гүйлгээний үр ашгийг нэмэгдүүлж байгаа боловч нөгөө талаас өгөгдлийн төвлөрөл, кибер халдлага, платформын давамгайлал, санхүүгийн бүрэн эрхийн асуудлыг бий болгож байна.

Иймээс энэхүү судалгааны үндсэн зорилго нь дижитал төлбөрийн системийн хөгжлийг эрх зүй–эдийн засгийн шинжилгээний үүднээс судалж, эдийн засгийн аюулгүй байдлыг хангах эрх зүйн зохицуулалтын онолын үндсийг тодорхойлоход оршино.

Дижитал эдийн засгийн эрчимтэй хөгжил нь төлбөрийн системийг санхүүгийн дэд бүтцийн хүрээнээс хальж өгөгдөл, технологи, үндэсний аюулгүй байдлын асуудалтай нягт холбогдох стратегийн институт болгон өөрчилж байна. Энэхүү өөрчлөлт нь эдийн засгийн үр ашиг, санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэхийн зэрэгцээ кибер эрсдэл, өгөгдлийн төвлөрөл, платформын давамгайлал, санхүүгийн бүрэн эрхийн шинэ

² <https://horasis.org/https://youtu.be/G3kL7mpl7-Y>

сорилтуудыг бий болгож байна. Иймээс дижитал төлбөрийн системийг зөвхөн технологийн үзэгдэл бус, харин эрх зүй-эдийн засгийн нийлмэл институтын хувьд судлах шаардлага үүсч байна.

1. Арга зүй.

Энэхүү судалгаанд эрх зүйн догматик арга, харьцуулсан эрх зүйн аргыг ашиглахын зэрэгцээ институцийн эрх зүй-эдийн засгийн шинжилгээг системийн хандлагаар хийхийг зорьсон.

2. Судалгааны үр дүн

Дижитал төлбөрийн системийн онолын үндэс

Дижитал төлбөрийн системийн дэлхийн хэмжээний хөгжил нь ХХ зууны сүүл үеэс электрон мөнгөн шилжүүлэг, төлбөрийн картын систем нэвтэрснээр эхэлсэн гэж үздэг. Эдгээр анхны систем нь банкны уламжлалт үйл ажиллагааг дижитал хэлбэрт оруулсан боловч төвлөрсөн, байгууллагад суурилсан шинжтэй байсан. Улмаар 1990-ээд оноос интернэт өргөнөөр ашиглагдаж эхэлснээр онлайн банк, цахим худалдаа, цахим хэвэвчүүд бий болж, хэрэглэгч болон аж ахуйн нэгжүүд зайнаас гүйлгээ хийх болсон. 2000-аад оноос финтек компаниудын өсөлт нь мобайл төлбөр, хүн хоорондын шилжүүлэг, платформд суурилсан төлбөрийн шийдлүүдийг нэвтрүүлж, инновацыг эрчимжүүлсэн нь төлбөрийн харилцааг бодит орон зайгаас салгаж, дижитал орчинд бүрэн шилжүүлэх болжээ. 2000 оноос хойш финтек салбар эрчимтэй хөгжиж, блокчэйн технологи, криптовалюта, төв банкны дижитал валют зэрэг төлбөрийн системийг төвлөрсөн бус, өгөгдөлд суурилсан шинэ шатанд хүргэсэн байна.³

Сүүлийн жилүүдэд блокчэйн болон тархмал бүртгэлийн технологи нь төвлөрсөн бус төлбөрийн систем, тухайлбал криптовалюта, стейблкойн зэргийг бий болгосон байна.

Энэ бүрэнд үндэслэн дижитал төлбөрийн системийн хөгжлийг түүний төрөл, дэд бүтцийн хөгжилтэй уялдуулан үечилж үзвэл:

Нэгдүгээрт, 1980-аас 1990-ээд онд DigiCash, E-cash зэрэг технологи, криптографийн зарчимд суурилсан, хэрэглэгчийн төлбөрийн аноним байдлыг хангах зорилготой криптографийн шийдлийг ашигласан эх орчин бүхий систем хөгжиж, анхны электрон төлбөрийн систем нэвтэрсэн үе;

Хоёрдугаарт, 1990-ээд оноос 2000-аад оны үед интернэт хэрэглээний цар хүрээ өргөжиж, онлайн худалдаа өсөх болсонтой уялдан кредит болон дебит карт, цахим түрийвч, онлайн банкны системүүд ихээр бий болж, интернет болон картын төлбөр өргөжсөн үе;

Гуравдугаарт, 2010-2019 онд ухаалаг гар утас, Near-Field Communication (NFC) ба QR кодоод суурилсан төлбөрийн хэрэгслүүд дэлхий даяар хэрэглэгдэж Mobile ба QR төлбөрүүд нэвтэрсэн үе;

Дөрөвдүгээрт, 2020 оноос хойш блокчэйн, Smart wallet, CBDC (Төв банкны дижитал валют) зэрэг төвлөрсөн биш, илүү хувь хүний хяналтад суурилсан шинэ

³ Victor Frimpong, *Managing Runaway AI: Lessons from Inflation Control for a Sustainable Artificial Intelligence Governance*, *Open Journal of Business and Management*, Vol.13 No.3, May 19, 2025

технологиуд нэвтэрсэн финтек ба крипто технологид суурилсан хөгжлийн үе гэж үечилж болно.

Эдгээр хувьслын үр дүнд төлбөрийн систем нь бэлэн мөнгөнөөс карт, картаас цахим банк, цахим банкнаас мобайл банк, мобайл банкнаас децентрализнагдсан платформ⁴ руу шилжсэн.

Дижитал төлбөрийн системийн хөгжил нь системийн хувьд төвлөрсөн системээс төвлөрсөн бус систем рүү шилжилт хийх замаар хөгжиж байгаа бөгөөд солилцооны зүйл нь бэлэн мөнгөнөөс өгөгдөлд суурилсан үнэ цэнийн солилцоо болж хувьсаж байгааг судалгааны олон эх сурвалжаар нотлогддог. Үүнийг дагаад дижитал төлбөрийн хэрэгслийн эдийн засгийн хүртээмж ба аюулгүй байдлыг уялдуулах, эрх зүйн зохицуулалт, кибер аюулгүй байдал, хэрэглэгчийн хамгаалалтыг улам бүр боловсронгуй болгох шаардлага ч улам бүр нэмэгдэж байна.

Харьцуулсан эрх зүйн судалгаанаас үзэхэд дижитал төлбөрийн системийн зохицуулалтын загвар нь улс орон бүрийн эрх зүйн уламжлал, эдийн засгийн хөгжлийн түвшин, төрийн бодлогын зорилтоос хамааран ялгаатай хөгжиж байна. Европын Холбоо нь PSD2 (Payment Services Directive 2)-т тулгуурласан нээлттэй банкны (Open Banking) загварыг хэрэгжүүлж, санхүүгийн зах зээл дэх өрсөлдөөнийг нэмэгдүүлэх, инновацийг дэмжих, хэрэглэгчдийн санхүүгийн мэдээлэлд хяналт тавих боломжийг өргөжүүлсэн хэдий ч зохицуулалтын өндөр шаардлага, нийцлийн зардал нь зах зээлд оролцогчдын ачааллыг нэмэгдүүлдэг талтай байна.⁵

Энэтхэг Улс нь UPI (Unified Payments Interface)-д суурилсан дижитал төлбөрийн тогтолцоог хөгжүүлж, санхүүгийн хүртээмжийг эрс нэмэгдүүлэн олон сая иргэнийг санхүүгийн системд хамруулж чадсан боловч хэрэглэгчийн мэдээллийн хамгаалалт, хувийн нууцтай холбоотой эрсдэлүүдийг бий болгож байна. Харин Сингапур Улс PayNow системээр дамжуулан бодит хугацааны төлбөрийн шийдлийг амжилттай нэвтрүүлж, финтек инновац болон цахим санхүүгийн үйлчилгээний хөгжлийг дэмжсэн боловч төлбөрийн системийн өндөр дижиталжилт нь кибер аюулгүй байдлын эрсдэлийг нэмэгдүүлэх хандлагатай байна.

БНХАУ-ын хувьд Alipay болон WeChat Pay платформд тулгуурласан дижитал төлбөрийн экосистем нь хэрэглээний түвшин, зах зээлийн нэвтрэлтээр дэлхийд тэргүүлэх хэмжээнд хүрсэн боловч цөөн тооны платформ зах зээлийг давамгайлах болсон нь өрсөлдөөний тэнцвэр алдагдах, өгөгдлийн төвлөрөл үүсэх, платформын засаглалтай холбоотой эрсдэлийг бий болгож байна.⁶ Монгол Улсын хувьд QRay зэрэг үндэсний платформд тулгуурласан дижитал төлбөрийн тогтолцоо нь хэрэглээний өсөлтөөрөө бүс нутагт анхаарал татахуйц түвшинд хүрч, QR төлбөрийн хэрэглээг эрчимтэй нэмэгдүүлсэн боловч хиймэл оюунд суурилсан санхүүгийн үйлчилгээ,

⁴ Децентрализнагдсан платформ гэдэг нь төвлөрсөн зуучлагч байгууллагаас үл хамааран, блокчэйн зэрэг тархмал технологид суурилсан, сүлжээний оролцогчдын хамтын баталгаажуулалтаар гүйлгээ, өгөгдөл, дүрмийг хэрэгжүүлдэг дижитал орчныг хэлнэ.

⁵ European Commission. Directive (EU) 2015/2366 on Payment Services in the Internal Market (PSD2).

⁶ People's Bank of China. China Payment System Development Reports.

өгөгдлийн бүрэн эрх, платформын засаглал, төв банкны дижитал валют зэрэг шинэ харилцааг зохицуулах эрх зүйн орчин харьцангуй хоцрогдсон хэвээр байна.

Улс	Загвар	Давуу тал	Эрсдэл
ЕХ	PSD2	Open Banking	Өндөр зардал
Энэтхэг	UPI	Санхүүгийн хүртээмж	Хувийн мэдээлэл
Сингапур	PayNow	Инноваци	Кибер эрсдэл
БНХАУ	Alipay/WeChat	Өндөр хэрэглээ	Платформ төвлөрөл
Монгол	QPay	Хурдан өсөлт	Эрх зүйн хоцрогдол

Энэхүү харьцуулсан судалгаанаас харахад дижитал төлбөрийн системийн хөгжлийн нийтлэг чиг хандлага нь инноваци, санхүүгийн хүртээмж, хэрэглээний өсөлтийг дэмжихэд чиглэж байгаа боловч үүнийг дагалдан өгөгдлийн хамгаалалт, кибер аюулгүй байдал, платформын төвлөрөл, хэрэглэгчийн эрхийн хамгаалалт зэрэг шинэ үеийн эрх зүйн сорилтууд бий болж байна.

Энэхүү хөгжлийн хандлага нь зөвхөн технологийн хөгжилд суурилсан бус, эдийн засгийн тогтвортой байдал, эрх зүйн зохицуулалт, санхүүгийн хүртээмжийг хамт дэмжих хэрэгцээг бий болгож байна..

Дэлхийн бэлэн бус төлбөрийн гүйлгээний хэмжээ 2007 оны 164.3 тэрбум ам.доллараас 2029 онд 3540.3 тэрбум ам.долларт хүрэх төлөвтэй байгаа нь ойролцоогоор 21 дахин өсөх хандлагатай байна. Өсөлтийг голлон Ази, Номхон далайн бүс (АРАС) манлайлж байгаа бөгөөд 2024-2029 оны нийлмэл жилийн өсөлтийн хурд (CAGR) 20.2%-д хүрч байна. Энэ нь дижитал төлбөрийн систем, мобайл банк, QR төлбөр, финтекийн үйлчилгээний эрчимтэй хөгжлийг илэрхийлж байна.⁷

Дэлхийн бэлэн бус төлбөрийн гүйлгээний өсөлтийн чиг хандлага, бүс нутгаар (2007–2029)

Бүс нутаг	Өсөлт (2024E–2025F)	CAGR (2024E–2029F)
Дэлхий нийт	17.4%	16.0%
АРАС	21.2%	20.2%
Европ	14.3%	10.8%
Хойд Америк	7.0%	7.8%
Латин Америк	22.4%	17.4%
МЕА	17.5%	13.9%

Дээрх статистик мэдээллээс үзэхэд төлбөрийн системийн хувьсал нь дараах чиглэлээр өрнөжээ.

Үе шат	Гол хэрэгсэл	Гол нөөц
I үе	Бэлэн мөнгө	Биет мөнгө

⁷ Capgemini Судалгааны хүрээлэнгийн Санхүүгийн үйлчилгээний шинжилгээ, 2025

II үе	Карт	Банкны данс
III үе	Цахим банк	Интернэт
IV үе	Мобайл төлбөр	Ухаалаг утас, өгөгдөл
V үе	Децентрализадсан платформ	Блокчэйн, алгоритм, өгөгдөл

Энэ шилжилтийн явцад төлбөрийн системийн гол үнэт зүйл нь мөнгөн тэмдэгтээс өгөгдөл (data) рүү, харин зохицуулалтын объект нь банкнаас платформ руу шилжиж байна. Иймээс орчин үеийн төлбөрийн системийн аюулгүй байдлыг зөвхөн санхүүгийн тогтвортой байдлаар бус, өгөгдлийн бүрэн эрх, кибер тогтвортой байдал, платформын засаглалын хүрээнд ойлгох шаардлагатай болж байна.⁸

Дижитал төлбөрийн системийн үр ашигтай, найдвартай үйл ажиллагааг хангахад:

- Технологийн дэд бүтэц: программ хангамж, сервер, криптографи, харилцаа холбооны сүлжээ;
- Санхүүгийн дэд бүтэц: клиринг, эцэслэлтийн систем, хөрвөх чадварын механизм;
- Эрх зүйн дэд бүтэц: төлбөр, цахим мөнгө, өгөгдөл хамгаалах, хэрэглэгчийн эрхийг зохицуулах хууль тогтоомж;
- Институцийн дэд бүтэц: төв банк, зохицуулах байгууллага, төлбөрийн үйлчилгээ үзүүлэгчдийг цогцоор нь авч үзэх шаардлага үүсдэг.

Түүнчлэн системийн кибер аюулгүй байдал, систем хоорондын нийцтэй байдал нь санхүүгийн зах зээл дэх талуудын итгэлцлийг хадгалах, санхүүгийн тогтвортой байдлыг хангахад онцгой ач холбогдолтой.

Дижитал төлбөрийн систем нь зөвхөн санхүүгийн хэрэгсэл бус, санхүүгийн салбарын засаглал, үйлчилгээний хүртээмж, төрийн санхүүгийн эрх мэдэл, эдийн засгийн оролцоо, технологийн чадавхыг тодорхойлох дараах гурван хэмжээсийн огтлолцолд оршино:

- Нэгдүгээрт, эдийн засгийн институт;
- Хоёрдугаарт, технологийн платформ;
- Гуравдугаарт, эрх зүйн зохицуулалтын объект.

Иймээс дижитал төлбөрийн системийг нийгэм–технологи–эрх зүйн нийлмэл институт гэж тодорхойлох боломжтой.⁹

Тиймээс ч дижитал төлбөрийн системийг эдийн засгийн онол, институцийн онол, технологийн онолтой уялдуулан авч үздэг.¹⁰

Дижитал төлбөрийн систем нь эдийн засгийн хэрэгцээ, технологийн боломж, хэрэглэгчийн шаардлагад тулгуурлан эдийн засгийн аюулгүй байдал, санхүүгийн хүртээмж, эрх зүйн зохицуулалттай салшгүй уялдах шаардлагыг харуулж байна.

⁸ World Payments Report 2026,

⁹ Rosane de F. A. Obregon, Tarcisio Vanzin, Vânia R. Ulbricht, *Different Perspectives of Creation and Knowledge Sharing in Virtual Environments, Creative Education, Vol.6 No.6, April 15, 2015*

¹⁰ Kahveci & Gurgur (2025) *Digital Payments and Sustainable Economic Growth: Transmission Mechanisms and Evidence from an Emerging Economy, Turkey*, https://www.mdpi.com/0718-1876/20/2/142?utm_source

Институцийн эдийн засгийн онолын төлөөлөгч Дуглас Норт (Douglass North)-ийн үзсэнэринститут нь тодорхой бус байдлыг бууруулж, эдийн засгийн оролцогчдын зан үйлийг зохицуулдаг дүрмийн тогтолцоо юм. Дижитал төлбөрийн систем нь гүйлгээний зардлыг бууруулах, зах зээлийн итгэлцлийг нэмэгдүүлэх институцийн механизм болж байна.

Эдийн засгийн хувьд дижитал төлбөрийн систем нь орчин үеийн эдийн засгийн салшгүй бүрэлдэхүүн хэсэг болж, олон давхаргат, цогц бүтэцтэй институц болон хөгжиж байна. Энэ нь санхүүгийн хүртээмж, тэгш боломж, хэрэглэгчийн эрхийг хангах асуудлыг *институцийн эдийн засгийн онолын дагуу* эдийн засгийн харилцаанд оролцогчдын зан төлөвийг уялдуулах, тодорхой бус байдлыг бууруулах чухал бүтэц гэж үздэг.¹¹ Эдийн засгийн талаас авч үзвэл эдгээр систем нь зах зээлийн үр ашгийг нэмэгдүүлж, гүйлгээний зардлыг бууруулж, харилцан итгэлцлийг хангах механизм болдог. Дугласын онол ёсоор дижитал төлбөрийн систем нь гүйлгээний зардлыг бууруулдаг шинэ институц юм.

Технологийн хувьд цахим платформ, криптографи, блокчэйн суурилагч протоколууд нь өгөгдлийн аюулгүй байдал, хувийн аюулгүй байлыг хангах механизмуудыг бий болгодог.

Shapiro ба Varian нарын сүлжээний онолоор төлбөрийн системийн үнэ цэнэ нь хэрэглэгчдийн тоо, платформ хоорондын нийцтэй байдлаас шууд хамаардаг. Энэ нь зах зээлийн төвлөрөл, монопол шинжийн эрсдэлийг бий болгодог. Харин *сүлжээний онолын хүрээнд* төлбөрийн системийн үнэ цэнэ нь оролцогчдын тоо, систем хоорондын нийцтэй байдал, хэрэглээний цар хүрээнээс шууд хамаардаг.¹²

Эрх зүйн хувьд цахим төлбөр болон мэдээллийн хамгааллын хуулийн орчин, байгууллагын хариуцлага, хэрэглэгчийн эрхийг хамгаалах механизм шаардна.

Ronald Coase-ийн гүйлгээний зардлын онол болон Ричард Познерийн эдийн засгийн үр ашгийн онолын дагуу эрх зүйн зохицуулалтын зорилго нь нийгмийн нийт зардлыг бууруулахад оршино. Дижитал төлбөрийн системийн зохицуулалт нь инновац болон аюулгүй байдлын хоорондын үр ашигтай тэнцвэрийг хангах ёстой. QR төлбөр, мобайл банк нь мэдээлэл хайх болон гэрээ байгуулах зардлыг бууруулдаг.

Эрх зүйн онолын хүрээнд дижитал төлбөрийн систем нь мөнгө, өмч, хяналт гэсэн уламжлалт ойлголтуудыг шинэчлэн тодорхойлох шаардлага бий болгож байна. Биет мөнгөнөөс өгөгдөлд суурилсан үнэ цэн рүү шилжих нь санхүүгийн бүрэн эрх, хэрэглэгчийн эрхийн хамгаалалт, өгөгдлийн засаглал, системийн эрсдэлийн асуудлыг бий болгож байна. Дижитал төлбөр нь мөнгө, өмч, өгөгдлийн эрхийн ойлголтыг дахин тодорхойлж, төрийн зохицуулалт, хэрэглэгчийн хамгаалалт, мэдээллийн аюулгүй байдлыг шаарддаг.

АНУ-ын холбооны шүүгч, эдийн засагч Ричард Познер (Richard Posner)-ийн санаачилсан эрх зүйн эдийн засгийн шинжилгээний онол нь хууль болон шүүхийн шийдвэрүүд нийгмийн эдийн засгийн үр ашиг буюу баялгийг нэмэгдүүлэх зорилготой

¹¹ Douglass North, *Institutions, Institutional Change, and Economic Performance*. New York: Cambridge University Press. 1990

¹² Shapiro & Varian, 1999, *Information Rules*

байх ёстой гэж үздэг. Тэрээр хууль зүйн салбарт үнийн онол, зардлын-үр ашгийн шинжилгээг нэвтрүүлсэн.

Баялаг бүтээх нь: Познерийн онолын гол цөм нь үйл явдал эсвэл хуулийн дүрэм нь нийт баялгийг өсгөж байна уу, үгүй юу гэдэг дээр тулгуурладаг. Тэрээр хэрэглэгчийн төлөхөд бэлэн байдал нь тухайн зүйлийн үнэ цэнийг хэмжих гол хэмжүүр гэж үздэг.

Зах зээлийг дуурайх: Хэрвээ гүйлгээний зардал өндөр, мэдээлэл дутмаг зэргээс шалтгаалан зах зээл бүрэн утгаараа ажиллах боломжгүй бол хууль эрх зүй нь зах зээлийн механизмтай төстэй үр дүнд хүргэхүйц байдлаар үйлчлэх ёстой.

Оновчтой үр дагавар: Познер Паретогийн үр ашгаас илүүтэйгээр Калдор-Хиксийн үр ашгийн шалгуурыг баримталдаг. Өөрөөр хэлбэл аливаа шийдвэрийн үр дүнд хохирол амсагчдаас илүү хожсон талын ашиг өндөр байж, хожсон нь хожигдсоноо нөхөн төлөх боломжтой (эцэстээ нийт баялаг өссөн) байхыг зөв гэж үздэг.

Эрх зүйн салбарт хэрэгжсэнээр өмчийн харилцааг тодорхой болгох замаар хүмүүсийг баялаг бүтээхэд урамшуулж, нөөцийн үргүй зарцуулалтыг зогсоох, талуудын сайн дурын үндсэн дээр гэрээний үнэ цэнийг нэмэгдүүлэх байдлаар хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлж, гэрээ зөрчигдсөн тохиолдолд оновчтой нөхөн төлбөрийг шаардах боломж бүрдэнэ гэж үзсэн байна.¹³ эх сурвалжаас дэлгэрэнгүй уншиж, судлах боломжтой. Төлбөрийн системийн эрх зүйн зохицуулалтын зорилго нь зөвхөн аюулгүй байдал биш, нийгмийн нийт үр ашгийг хамгийн их болгох явдал юм.

Иймд дижитал төлбөрийн системийн төрөл, дэд бүтцийг оновчтой ойлгож, инноваци ба тогтвортой байдал, үр ашиг ба хүртээмж, технологийн дэвшил ба эрх зүйн баталгааны хооронд тэнцвэрийг хангах нь бодлого боловсруулагчид, судлаачдын өмнө тавигдах чухал зорилт юм.

Эдгээр гурван салбарын зохистой тэнцвэр нь дижитал төлбөрийн системийг хүний эрх, шударга өрсөлдөөн, технологийн инновацид нийцүүлэн хөгжүүлэх гол зарчим болдог.

Монгол Улсын өнөөгийн хууль, эрх зүйн орчинд шинжилгээ

Монгол Улсад дижитал төлбөрийн харилцааг зохицуулах эрх зүйн үндэс нь олон эх сурвалжаас бүрдсэн нэгдмэл тогтолцоо юм. Энэхүү тогтолцоо нь санхүүгийн тогтвортой байдал, хэрэглэгчийн эрхийн хамгаалалт, мэдээллийн аюулгүй байдал, цахим гүйлгээний найдвартай байдлыг хангахад чиглэдэг.

Монгол Улсад дижитал төлбөрийн систем, цахим мөнгө, мобайл банк, QR төлбөр, интернэт банк болон бусад финтек үйлчилгээний эрх зүйн орчныг дараах хууль тогтоомжууд бүрдүүлж байна. Монгол Улсын Үндсэн хууль нь өмчлөх эрх, эдийн засгийн үйл ажиллагаа эрхлэх эрх чөлөө, хувийн нууц, мэдээллийн хамгаалалтын үндсэн зарчмыг тогтоосон. Төрөлжсөн хуулиудыг авч үзвэл:

1. Үндэсний төлбөрийн системийн тухай хууль

Дижитал төлбөрийн үйлчилгээний суурь хууль бөгөөд үндэсний төлбөрийн системийг удирдах, зохицуулах, хяналт тавих, төлбөрийн үйлчилгээ үзүүлэгчид

¹³ *Stanford Encyclopedia of Philosophy - Economic Analysis of Law*

зөвшөөрөл олгох, төлбөрийн хэрэгсэл гаргах, цахим мөнгөний үйл ажиллагааг зохицуулах үндсэн эрх зүйн орчныг тогтоодог.

2. Төв банк (Монголбанк)-ны тухай хууль

Монголбанкны төлбөрийн системийг зохицуулах, хяналт тавих бүрэн эрхийг тодорхойлж, үндэсний төлбөрийн системийн тогтвортой ажиллагааны эрх зүйн үндсийг бүрдүүлдэг.

3. Цахим гарын үсгийн тухай хууль

Цахим орчинд гэрээ байгуулах, төлбөрийн гүйлгээг баталгаажуулах, хэрэглэгчийг таньж баталгаажуулах (authentication) эрх зүйн үндсийг бүрдүүлдэг.

4. Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны эрх зүйн багц хууль

Цахим баримт бичиг, цахим үйлчилгээ, цахим мэдээллийн солилцоо болон төр-хувийн хэвшлийн дижитал үйлчилгээний орчныг бүрдүүлдэг.

5. Банкны тухай хууль

Банкны цахим үйлчилгээ, төлбөр тооцоо, цахим сувгаар үзүүлэх санхүүгийн үйлчилгээний эрх зүйн үндсийг тогтооно.

6. Хувь хүний мэдээлэл хамгаалах тухай хууль

Дижитал төлбөрийн хэрэглэгчийн мэдээллийн аюулгүй байдал, нууцлал, өгөгдөл боловсруулах үйл ажиллагааг зохицуулна.

7. Кибер аюулгүй байдлын тухай хууль

Төлбөрийн системийн мэдээллийн дэд бүтэц, өгөгдлийн хамгаалалт, цахим халдлагаас сэргийлэх эрх зүйн механизмыг тогтоодог.

8. Монголбанкны дүрэм, журам

- Цахим мөнгөний журам
- Төлбөрийн системийн журам
- QR кодын стандарт
- Төлбөрийн картын үйл ажиллагааны журам
- Төлбөрийн үйлчилгээ үзүүлэгчид зөвшөөрөл олгох журам зэрэг нь дижитал төлбөрийн өдөр тутмын үйл ажиллагааг нарийвчлан зохицуулдаг.

Монгол Улсын дижитал төлбөрийн системийн эрх зүйн зохицуулалт нь 2017 онд батлагдсан Үндэсний төлбөрийн системийн тухай хуулиар шинэ шатанд гарч, банк төвтэй уламжлалт төлбөрийн тогтолцооноос финтек болон банк бус оролцогчдыг хамарсан нээлттэй экосистем рүү шилжих эрх зүйн суурь нөхцөлийг бүрдүүлсэн байна. Энэхүү хууль нь төлбөрийн үйлчилгээ үзүүлэгч, цахим мөнгө гаргагч, төлбөрийн системийн оператор зэрэг шинэ субъектүүдийг хуульчилж, Монголбанкны зохицуулах болон хяналт тавих бүрэн эрхийг тодорхой болгосон нь дижитал санхүүгийн зах зээлийн хөгжлийн чухал урьдчилсан нөхцөл болсон.

Монгол Улсын дижитал төлбөрийн системийн эрх зүйн орчинд SWOT шинжилгээ хийж үзэхэд суурь институцийн хувьд тодорхой хэмжээнд бүрэлдэн тогтсон боловч технологийн хөгжлийн шинэ үеийн шаардлагыг бүрэн хангах түвшинд хараахан хүрээгүй байна. Үндэсний төлбөрийн системийн зохицуулалт, Монголбанкны хяналт, банк хоорондын төлбөрийн дэд бүтэц, QR төлбөр болон цахим мөнгөний хэрэглээний өсөлт нь дижитал төлбөрийн экосистем хөгжих үндсэн нөхцөлийг бүрдүүлсэн. Энэ нь Монгол Улсад санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх, төлбөр тооцооны хурд, зардал,

хүртээмжийг сайжруулах, иргэдийн өдөр тутмын эдийн засгийн харилцааг цахим хэлбэрт шилжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэж байна.

Гэвч эрх зүйн зохицуулалтын өнөөгийн бүтэц нь дижитал төлбөрийн системийг зөвхөн санхүүгийн үйлчилгээний хүрээнд авч үзэх хандлагатай байгаа нь өгөгдөл, платформ, алгоритм, кибер аюулгүй байдал, үндэсний эдийн засгийн аюулгүй байдлын асуудлыг бүрэн хамрахад хангалтгүй байна. Тухайлбал, төлбөрийн гүйлгээний өгөгдлийн өмчлөл, ашиглалт, хил дамнансан шилжилт, арилжааны үнэ цэнэ, өгөгдлийн бүрэн эрхийн асуудал одоогийн хууль тогтоомжид системтэйгээр тусгагдаагүй байна. Энэ нь цаашид төлбөрийн мэдээлэл цөөн платформ дээр төвлөрөх, гадаад серверт хадгалагдах, эсхүл өгөгдлийн эдийн засгийн үнэ цэнэ үндэсний хяналтаас гадуур ашиглагдах эрсдэлийг бий болгож болзошгүй юм.

Мөн финтек платформ, төлбөрийн агрегатор, супер аппликейшн, хиймэл оюун ухаанд суурилсан эрсдэлийн үнэлгээ, хэрэглэгчийн сегментчлэл зэрэг шинэ төрлийн үйлчилгээ нь уламжлалт банк, төлбөрийн үйлчилгээний зохицуулалтын хүрээнээс давж хөгжиж байна. Ийм нөхцөлд алгоритмын ил тод байдал, хэрэглэгчийн эрхийн хамгаалалт, өгөгдөл ашиглалтын зөвшөөрөл, платформын давамгайл байдал, өрсөлдөөний тэнцвэр зэрэг асуудлыг тусгайлан зохицуулах шаардлага бий болж байна. Хэрэв эдгээр харилцааг эрх зүйн хувьд тодорхой болгохгүй бол дижитал төлбөрийн систем нь санхүүгийн инновацыг дэмжихийн зэрэгцээ шинэ төрлийн эрх зүйн тодорхойгүй байдал, хэрэглэгчийн эмзэг байдал, зах зээлийн төвлөрлийн эрсдэлийг нэмэгдүүлэх магадлалтай.

Түүнчлэн төв банкны дижитал валютын эрх зүйн орчин Монгол Улсад бүрэн төлөвшөөгүй байгаа нь цаашдын томоохон сорилтын нэг юм. CBDC нэвтрүүлэх тохиолдолд түүний мөнгөний эрх зүйн статус, төлбөрийн хэрэгслийн хүчин төгөлдөр байдал, хэрэглэгчийн мэдээллийн хамгаалалт, хувийн нууц, кибер аюулгүй байдал, мөнгөний бодлогын хэрэгжилттэй уялдах асуудлыг урьдчилан зохицуулах шаардлагатай. Иймээс CBDC-ийн эрх зүйн зохицуулалт нь зөвхөн төлбөрийн техник хэрэгслийн асуудал бус, харин мөнгөний бүрэн эрх, санхүүгийн тогтвортой байдал, төрийн дижитал дэд бүтцийн засаглалтай шууд холбогдох стратегийн шинжтэй асуудал гэж үзэх үндэслэлтэй.

SWOT шинжилгээний дүнд үндэсэн өнөөгийн эрх зүйн орчин нь эдийн засгийн ямар үр нөлөө бий болгож байгаад анализ хийж үзвэл Монгол Улсын дижитал төлбөрийн эрх зүйн зохицуулалт нь төлбөрийн үйлчилгээний найдвартай ажиллагаа, санхүүгийн тогтвортой байдлыг хангах суурь институцийн орчныг бүрдүүлж, бүс нутгийн хэмжээнд харьцангуй дэвшилтэт түвшинд хүрсэн хэдий ч дижитал төлбөрийн технологийн хурдацтай хөгжилтэй харьцуулахад хиймэл оюунд суурилсан санхүүгийн үйлчилгээ, нээлттэй банк, өгөгдөлд суурилсан эдийн засаг, төв банкны дижитал валют, өгөгдлийн бүрэн эрх, платформын засаглал болон кибер аюулгүй байдлын шинэ сорилтуудыг цогцоор нь зохицуулах түвшинд хараахан хүрээгүй байгаа тул цаашдын эрх зүйн шинэчлэл нь төлбөрийн системийг зөвхөн санхүүгийн үйлчилгээний хэрэгсэл бус, харин үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, дижитал тусгаар тогтнол, өгөгдлийн засаглалтай нягт холбогдсон стратегийн дэд бүтэц гэж үзэх үзэл баримтлалд тулгуурлан технологийн төвийг сахисан, эрсдэлд суурилсан, инновацыг дэмжсэн зохицуулалтын тогтолцоог бүрдүүлэхэд чиглэх шаардлагатай байна.

Асуудлыг схемчлэн харуулбал:

Эрх зүйн асуудал	Эдийн засгийн нөлөө
Өгөгдлийн өмчлөл тодорхойгүй	Итгэлцэл буурна
Кибер халдлага	Гүйлгээний зардал өснө

Монопол платформ	Өрсөлдөөн буурна
CBDC зохицуулалтгүй	Санхүүгийн тогтвортой байдал алдагдана
Хэрэглэгчийн хамгаалалт сул	Зах зээлийн оролцоо буурна

Иймд Монгол Улсын дижитал төлбөрийн системийн эрх зүйн шинэчлэл нь төлбөрийн үйлчилгээний уламжлалт зохицуулалтаас давж, өгөгдлийн бүрэн эрх, платформын засаглал, алгоритмын хариуцлага, кибер тогтвортой байдал, өрсөлдөөний эрх зүй, хэрэглэгчийн эрхийн хамгаалалтыг нэгтгэсэн цогц зохицуулалтын загварт шилжих шаардлагатай байна. Дижитал төлбөрийн системийг цаашид зөвхөн банк, санхүүгийн үйлчилгээний нэг төрөл бус, харин үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, дижитал тусгаар тогтнол, мэдээллийн бүрэн эрхийг хангах стратегийн дэд бүтэц гэж үзэх нь зүйтэй. Энэ хандлага нь Монгол Улсын төлбөрийн системийн эрх зүйн бодлогыг инновацыг дэмжих, эрсдэлийг урьдчилан сэргийлэх, хэрэглэгчийг хамгаалах, үндэсний өгөгдлийн ашиг сонирхлыг баталгаажуулах чиглэлд шинэ шатанд гаргах онол, практикийн ач холбогдолтой юм.

3. Дүгнэлт

Энэхүү судалгаагаар дижитал төлбөрийн систем нь санхүүгийн технологийн дэвшлийн үр дүнд бий болсон төлбөр тооцооны хэрэгсэл төдий бус, харин өгөгдлийн засаглал, эдийн засгийн аюулгүй байдал, үндэсний бүрэн эрх, хүний эрхийн хамгаалалтыг нэгтгэн илэрхийлэгч стратегийн ач холбогдол бүхий институцийн тогтолцоо болох нь тогтоогдов. Дэлхийн хэмжээнд дижитал төлбөрийн хэрэглээ эрчимтэй өсөж, төлбөрийн систем нь бэлэн мөнгөнд суурилсан уламжлалт загвараас өгөгдөлд суурилсан дижитал экосистем рүү шилжиж байгаа бөгөөд Монгол Улс энэхүү шилжилтийн үйл явцад хамгийн идэвхтэй оролцож буй орнуудын нэг болж байна.

Судалгааны үр дүнгээс үзэхэд Монгол Улсад дижитал төлбөрийн хэрэглээ өндөр түвшинд хүрч, QR төлбөр, мобайл банк, цахим худалдаа, төрийн үйлчилгээний цахим төлбөрийн хэрэглээ өргөн дэлгэрсэн нь санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх, төлбөрийн үр ашгийг сайжруулах, эдийн засгийн эргэлтийг хурдасгах чухал хүчин зүйл болж байна. Үүний зэрэгцээ төлбөрийн системийн хөгжлийн төв нь мөнгөн хөрөнгийн хөдөлгөөнөөс өгөгдлийн урсгал руу шилжиж байгаа нь төлбөрийн системийг зөвхөн санхүүгийн бус, мэдээллийн болон стратегийн дэд бүтцийн шинжтэй болгож байна.

Харьцуулсан эрх зүйн судалгаанаас харахад АНУ инновацид суурилсан, Европын Холбоо эрхэд төвлөрсөн, Энэтхэг санхүүгийн хүртээмжийг дэмжсэн, Кени мобайл төлбөрийн хүртээмжийг өргөжүүлсэн загварыг хэрэгжүүлж байгаа бол Монгол Улсын хувьд эдгээрийн давуу талыг хослуулсан холимог загвар бүрэлдэж байгаа хэдий ч өгөгдлийн өмчлөл, платформын засаглал, хиймэл оюунд суурилсан санхүүгийн үйлчилгээ, төв банкны дижитал валютын зохицуулалт зэрэг шинэ үеийн асуудлыг бүрэн хамарч чадаагүй хэвээр байна.

SWOT шинжилгээний үр дүнгээс үзэхэд Монгол Улсын дижитал төлбөрийн эрх зүйн орчин нь төлбөрийн үйлчилгээний үндсэн зохицуулалт, цахим гарын үсэг, хувийн мэдээлэл хамгаалах болон кибер аюулгүй байдлын суурь тогтолцоог бүрдүүлсэн давуу талтай боловч өгөгдлийн бүрэн эрхийн тодорхой бус байдал, финтек платформын зохицуулалтын сул хөгжил, төв банкны дижитал валют болон хиймэл оюунд суурилсан үйлчилгээний эрх зүйн зохицуулалтын хоцрогдол зэрэг сул талууд ажиглагдаж байна. Үүний зэрэгцээ финтекийн өсөлт, цахим засаглалын хөгжил, өгөгдөлд суурилсан эдийн засгийн тэлэлт нь шинэ боломжийг бий болгож байгаа боловч кибер халдлага,

платформын төвлөрөл, гадаад технологийн хараат байдал, өгөгдлийн бүрэн эрх алдагдах эрсдэл нь үндэсний эдийн засгийн аюулгүй байдалд нөлөөлөх хүчин зүйл болж байна.

Иймд Монгол Улсын дижитал төлбөрийн системийн эрх зүйн хөгжлийн дараагийн үе шат нь төлбөрийн системийг зөвхөн санхүүгийн үйлчилгээний хэрэгсэл гэж бус, харин үндэсний стратегийн дижитал дэд бүтэц гэж үзэх үзэл баримтлалд тулгуурлах шаардлагатай байна. Энэхүү зорилтыг хэрэгжүүлэхийн тулд өгөгдлийн бүрэн эрхийг хангах, кибер тогтвортой байдлыг бэхжүүлэх, технологийн төвийг сахисан зохицуулалтыг төлөвшүүлэх, шударга өрсөлдөөнийг дэмжих, хэрэглэгчийн эрхийг үр нөлөөтэй хамгаалах гэсэн таван тулгуур зарчимд суурилсан эрх зүйн загварыг хөгжүүлэх нь зүйтэй гэж үзэв.

Эцэст нь дүгнэхэд, дижитал төлбөрийн системийн эрх зүйн зохицуулалтын зорилго нь инновацыг хязгаарлах бус, харин инноваци, эдийн засгийн үр ашиг, кибер тогтвортой байдал, хүний эрхийн хамгаалалт болон үндэсний аюулгүй байдлын ашиг сонирхлын хоорондын тэнцвэрийг хангах институцийн орчныг бүрдүүлэхэд чиглэх ёстой бөгөөд энэ нь Монгол Улсын дижитал эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангах эрх зүйн бодлогын үндсэн чиглэл болох шаардлагатай байна.

4. Эх сурвалж:

- Шихихутуг их сургуулийн Бизнесийн удирдлагын тэнхимийн ахлах багш, докторант
- <https://horasis.org/https://youtu.be/G3kL7mpl7-Y>
- Victor Frimpong, *Managing Runaway AI: Lessons from Inflation Control for a Sustainable Artificial Intelligence Governance*, *Open Journal of Business and Management*, Vol.13 No.3, May 19, 2025
- Cargemini Судалгааны хүрээлэнгийн Санхүүгийн үйлчилгээний шинжилгээ, 2025
- *World Payments Report 2026*,
- Rosane de F. A. Obregon, Tarcisio Vanzin, Vânia R. Ulbricht, *Different Perspectives of Creation and Knowledge Sharing in Virtual Environments*, *Creative Education*, Vol.6 No.6, April 15, 2015
- Kahveci & Gurgur (2025) *Digital Payments and Sustainable Economic Growth: Transmission Mechanisms and Evidence from an Emerging Economy*, Turkey, https://www.mdpi.com/0718-1876/20/2/142?utm_source
- Douglass North, *Institutions, Institutional Change, and Economic Performance*. New York: Cambridge University Press.1990
- Shapiro & Varian, 1999, *Information Rules*
- *Stanford Encyclopedia of Philosophy-Economic Analysis of Law*